



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

Цахим хаяг: Narantuuld@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	17
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	17
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	17
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	20

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ДӨРГӨН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН  
ЗАХИРАГЧ Л.ЦЭДЭН-ИШ ТАНАА

2023.03.05 № 02/116  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Дөргөн сумын татварын орлогыг 329.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нийт орлогыг 51.9 сая төгрөгөөр буюу 13.6 хувиар тасалсан гол шалтгаан нь малын тоо толгойн албан татвар 36.0, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 15.9, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 6.0, шууд бус орлого 14.7, үйл ажиллагааны орлого 4.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,128.8 сая төгрөг буюу 84.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 13.4, байр ашиглахтай холбоотой зардал 26.4, урсгал шилжүүлэг 26.7, хөрөнгийн зардалд 97.4, Хоршоо хөгжүүлэх санг 48.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн үзүүлэлттэй байна.

## Аудитын гол асуудал

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

## Бусад асуудлын хэсэг

021020424

Сумын ИТХ-ын 12/03 тогтоолоор Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 6 бодлогын хүрээнд 129 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 86.5 хувийн биелэлттэй гэж үнэлэгджээ.

Тайлант онд "Дөрвөд угсаатны өв соёлын анхдугаар наадам"-ыг зохион байгуулан өнгөрүүлсэн байна.

ЗДТГ-аас 2021 онд сонгуулийн үр дүнд чөлөөлөгдсөн 6 албан тушаалтанд 28.0 сая төгрөг, тэтгэвэрт гаргахад олгодог нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 45.0 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгогджээ.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	774,907.1	647,171.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	137,004.0	213,621.0
33	АВЛАГА	261,563.6	266,251.2
34	УРЬДЧИЛГАА	138,989.3	117,689.3
35	БАРАА МАТЕРИАЛ	237,350.3	49,610.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,665,849.4	2,377,401.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,665,849.4	2,377,401.9
39200	Биет хөрөнгө	5,544,136.7	2,342,923.7
39300	Биет бус хөрөнгө	121,712.7	34,478.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,440,756.6	3,024,573.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,426.6	25,250.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,426.6	25,250.2
41300	Өглөг	6,426.6	25,250.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,434,330.0	2,999,323.2
51	Засгийн газрын хувь оролцоо	6,434,330.0	2,999,323.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,103,139.8	795,806.1
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	-	795,806.1
51200	Хуримтлагдсан үр дүн	2,781,907.6	2,021,348.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,549,282.6	182,169.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,440,756.6	3,024,573.4

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,568,248.5	3,181,675.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	86,815.0	308,754.6
110	Орлогын албан татвар	57,073.3	265,258.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	57,073.3	265,258.1
113	Хөрөнгийн албан татвар	23,387.7	29,364.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	6,354.0	14,131.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	768,895.6	1,560,270.6
120	Нийтлэг татварын бус орлого	768,895.6	1,560,270.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,712,538.0	1,312,650.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,135,388.6	1,405,709.3

21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,135,388.6	1,405,709.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,014,002.5	1,331,180.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,700,547.4	326,771.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	217,738.2	41,630.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,400.2	367,229.0
2104	Хангамж, бараа материалын зардал	193,371.1	168,098.7
2105	Нормативт зардал	158,285.9	128.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,073.1	10,201.8
2107	Томилолт, зочны зардал	3,559.7	2,904.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,477.9	8,712.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,549.1	405,503.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,386.0	74,529.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	432,859.9	1,775,966.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,392.4	4,589,102.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	426,467.5	(2,813,135.8)

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,859,089.7	1,228,551.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	86,815.0	308,754.6
110	Орлогын албан татвар	57,073.3	265,258.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	57,073.3	265,258.1
113	Хөрөнгийн албан татвар	23,387.7	29,364.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	6,354.0	14,131.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,311.5	6,487.5
1181	Газрын төлбөр	1,604.5	5,806.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,438.0	1,838.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,888.3	61,368.5
120	Нийтлэг татварын бус орлого	81,888.3	61,368.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,690,386.4	858,428.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,597,447.4	978,618.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,597,447.4	978,618.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,470,180.1	872,435.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,692,743.9	326,747.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,635.1	41,624.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,083.9	367,229.0

2104	Хангамж, бараа материалын зардал	64,875.5	26,929.7
2105	Нормативт зардал	146,830.0	128.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,119.7	10,201.8
2107	Томилолт, зочны зардал	4,009.6	2,904.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,702.1	8,772.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,180.2	87,897.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,267.3	106,182.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	261,642.3	249,933.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	207,831.5	172,216.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	207,831.5	172,216.4
2200	Дотоод эх үүсвэрээр	207,831.5	172,216.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(207,831.5)	(172,216.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(1,100.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	1,100.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	53,810.8	76,617.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	83,193.2	137,004.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	137,004.0	213,621.0

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр )

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,760,074.3	5,760,074.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	247,788.1	247,788.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,007,862.5	6,007,862.5
9	Тайлант үеийн үр дүн	426,467.5	426,467.5
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,434,330.0	6,434,330.0
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,434,330.0	6,434,330.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(158,637.9)	(158,637.9)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,275,692.1	6,275,692.1
19	Тайлант үеийн үр дүн	(3,276,368.9)	(3,276,368.9)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,999,323.2	2,999,323.2

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр )

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,343,536.7</b>	<b>1,128,824.5</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,023,897.6</b>	<b>955,508.1</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>893,952.2</b>	<b>852,292.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>340,193.3</b>	<b>326,747.8</b>
210101	Үндсэн цалин	234,815.5	215,758.4
210102	Нэмэгдэл	55,231.4	56,117.8
210104	Урамшуулал	8,683.6	16,551.4
210105	Гэрээт ажлын хөлс	41,462.8	38,320.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,407.9</b>	<b>41,624.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,916.8	28,380.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,211.6	3,158.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,794.9	2,745.7
210204	Ажилгүйдлийн даатгал	680.5	671.8
210205	Эрүүл мэндийн даатгал	6,804.1	6,667.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>393,593.1</b>	<b>367,228.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,393.3	18,218.0
210302	Түлш, халаалт	366,910.8	343,842.6
210303	Цэвэр, бохир ус	6,289.0	5,168.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,970.1</b>	<b>26,929.7</b>
210401	Бичиг хэрэг	4,206.6	4,206.6
210402	Тээвэр, шатахуун	19,419.3	19,419.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,344.2	3,303.8
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>128.3</b>	<b>128.3</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	128.3	128.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,751.8</b>	<b>10,201.8</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	167.0	158.9
210604	Урсгал засвар	10,584.8	10,042.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,016.1</b>	<b>2,904.6</b>
210702	Дотоод албан томилолт	3,016.1	2,904.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,975.1</b>	<b>8,772.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,662.1	7,567.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330.0	260.0
210803	Даатгалын үйлчилгээ	145.0	145.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	615.0	608.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	30.0	30.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	140.0	140.0

210807	Газрын төлбөр	53.0	21.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>67,916.5</b>	<b>67,754.6</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,916.5	67,754.6
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>129,945.4</b>	<b>103,215.9</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>55,376.3</b>	<b>28,673.3</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	55,376.3	28,673.3
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>74,569.1</b>	<b>74,542.6</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,014.2	28,014.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	45,404.9	45,404.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,150.0	1,123.5
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>269,639.1</b>	<b>172,216.4</b>
220001	Барилга байгууламж	93,317.1	57,187.9
221001	Их засвар	53,500.0	50,622.0
222001	Тоног төхөөрөмж	2,335.9	2,335.0
223001	Бусад хөрөнгө	120,486.1	62,071.6
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>50,000.0</b>	<b>1,100.0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	50,000.0	1,100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,343,536.7</b>	<b>1,207,531.3</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,259,041.8</b>	<b>1,166,720.4</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,038,852.2	946,530.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	220,189.6	220,189.6
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>84,494.9</b>	<b>40,811.0</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,005.0	1,665.0
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,610.2	39,146.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	69,879.7	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	77,076.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	152,816.6
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>96</b>	<b>96</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>6</b>	<b>6</b>
610001	Төсвийн байгууллага	6	6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>45</b>	<b>45</b>
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	20	20
620004	Гэрээт ажилтан	7	7
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>45</b>	<b>45</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	10

650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	25	25
650010	Гэрээт ажилтан	3	3
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр )

Код	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>192,551.4</b>	<b>41,311.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>192,551.4</b>	<b>41,311.9</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>138,532.4</b>	<b>20,143.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>23,117.0</b>	<b>-</b>
210101	Үндсэн цалин	12,421.3	-
210102	Нэмэгдэл	10,695.7	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>2,944.2</b>	<b>-</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,944.2	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>200.0</b>	<b>-</b>
210301	Гэрэл, цахилгаан	200.0	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,381.4</b>	<b>-</b>
210401	Бичиг хэрэг	1,157.9	-
210402	Тээвэр, шатахуун	5,923.2	-
210404	Ном, хэвлэл	2,631.8	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,668.6	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>52,175.9</b>	<b>-</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,335.9	-
210502	Хоол, хүнс	1,840.0	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>754.5</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	754.5	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,959.3</b>	<b>20,143.3</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,395.3	19,846.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,564.0	297.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,019.0</b>	<b>21,168.6</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,469.9</b>	<b>-</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,069.9	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,400.0	-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,549.1</b>	<b>21,168.6</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,549.1	21,168.6
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>192,551.4</b>	<b>41,311.9</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>192,551.4</b>	<b>41,311.9</b>

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,500.0	13,732.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,195.6	25,243.4
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,807.3	2,335.9
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	87,048.5	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дөргөн сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,
- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн нэмэлт өөрчлөлтүүд орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

Дөргөн сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,416.1 сая төгрөгөөр буюу 53 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/*

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	137.0	213.6	(76.6)	1.6
Авлага	261.6	266.3	(4.7)	1.0
Урьдчилгаа	139.0	117.7	21.3	0.8
Бараа материал	237.3	49.6	187.7	0.2
Үндсэн хөрөнгө	5,665.8	2,377.4	3,288.4	0.4
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,440.7</b>	<b>3,024.6</b>	3,416.1	0.5
Богино хугацаат өр төлбөр	6.4	25.3	(18.9)	4.0
Цэвэр хөрөнгө, өмч	6,434.3	2,999.3	3,435.0	0.5
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,440.7</b>	<b>3,024.6</b>	3,416.1	0.5

*Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад, *санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн данснууд байна.*

*Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө 40 хувиар буурсан гол шалтгаан нь орон нутгийн ЭМТөв, ЕБСургууль, СӨБ, Соёлын байгууллагууд нь улсын төсвөөс санхүүжилт авч тайлан балансаа харьяаны салбарт нэгтгээдэг болсонтой холбоотой байна.*

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 137.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 213.6 сая төгрөг болж 76.6 сая төгрөгөөр буюу 60 хувиар өссөн нь тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зээл олгоогүй, ОНХС-аас хэрэгжүүлэх арга хэмжээг дараа он руу шилжүүлсэнтэйгээр өссөн байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 266.3 сая төгрөг болж, өмнөх оноос 4.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.5		(2.5)
Төлбөртэй үйлчилгээний авлага	26.0		(26.0)
Байгууллагаас авах авлага	0.7	39.6	38.9
Хувь хүмүүсээс авах авлага	2.6	7.8	5.2
Зээлийн хүүгийн авлага	227.9	218.9	(9.0)
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/	1.8		(1.8)
<b>Дүн</b>	<b>261.5</b>	<b>266.3</b>	<b>4.8</b>

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өссөн гол шалтгаан нь ОНХС-аас хийгдсэн гэрэлтүүлгийн ажил бүрэн хийгдээгүй, малчдад олгосон өвсний үнэ бүрэн төлөгдөөгүй зэрэгтэй холбоотой байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Тайлант оны эхэнд 139.0 сая төгрөг, оны эцэст урьдчилгаа дансны үлдэгдэл 117.7 сая төгрөг байна.

Хүснэгт 3. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	125.5	117.7	(7.8)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	13.0		(13.0)
Цалингийн урьдчилгаа	0.5		(0.5)
<b>Дүн</b>	<b>139.0</b>	<b>117.7</b>	<b>(21.3)</b>

Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан авлагын 2016 онд жишиг хашааны авлага 27.0, малжуулах төслийн 90.7, сая төгрөгийн авлагыг тайлант онд гэрээний дагуу ОНХС-ийн төвлөрүүлэн залуу малчдыг дэмжих зорилгоор малжуулах төсөлд хамруулан барагдуулах боломжтой байна.

### 3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 49.6 сая төгрөг болж 187.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материал дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Түүхий эд материал</b>	<b>43.3</b>	<b>1.5</b>	<b>41.8</b>
Тусгай зориулалттай материал	31.4	1.5	29.9
Эм боох материал	11.9		11.9
<b>Хангамжийн материал</b>	<b>194.0</b>	<b>48.1</b>	<b>145.9</b>
Бичиг хэргийн материал	0.8	0.4	0.4
Аж ахуйн материал	138.4	32.3	106.1
Хүнсний материал	6.1		6.1
Бусад хангамжийн материал	33.5	0.2	33.3
Мал амьтад	15.2	15.2	-
<b>Нийт бараа материал</b>	<b>237.3</b>	<b>49.6</b>	<b>187.7</b>

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгө, ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан бараа материалыг үнэ төлбөргүйгээр нийт 88.7 сая төгрөгийн бараа материалын орлого бүрдүүлж, 79.5 сая төгрөгийн материалыг зарцуулж, 196.9 сая төгрөгийн бараа материалыг улсын төсвийн байгууллагуудын балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

#### 3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 7,685,4 сая төгрөг байсан тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.3 сая, УТХО-оор 1,487.6 сая төгрөгөөр Чоно хайрахын зам гүүрийг ОНХС-ийн хөрөнгөөр 16.6 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 5,291.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж оны эцэст 3,900.5 сая төгрөг болж 3,784.9 сая төгрөгөөр буурсан байна.

#### 3.4.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 6.4 сая, эцсийн үлдэгдэл 25.2 сая төгрөг болж 18.8 сая төгрөгөөр буурсан байна. Өр төлбөрийн 88.1 хувь буюу 11.9 сая төгрөгийн өр төлбөр нь хог хаягдлыг дарж устгах ажлын үлдэгдэл, аймгийн ЗДТГ-ын 10.0 сая төгрөгийн өглөг нь, бусад нь ИТХ, ОНХС, Хоршоо хөгжүүлэх сангийн өр төлбөрийн үлдэгдэл байна.

#### 3.4.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 6,434.3 сая төгрөг байснаас оны эцэст 2,999.3 сая төгрөг болж 3,435.0 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллагын хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой, ЗДТГ-ын хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй илэрхийлсэнтэй холбоотой 1,778.0 сая төгрөгөөр өмнөх үеийн үр дүн дансанд залруулга хийсэн.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,052.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1213.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дөргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 7/04 тоот тогтоолоор 1,423.0 сая

төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор 2022 онд 1 удаа тодотгон 2022 оны 07 дугаар сарын 28-ны 9/02 тоот тогтоолоор нийт 1,343.5 сая төгрөгөөр буюу аймгаас олгох санхүүжилтийг 114.2 сая төгрөгөөр бууруулан, татварын орлогыг 53.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,343.5 сая төгрөгийн төсөв баталснаас орон нутгийн төсвөөс 1,038.3, ОНХС-аас 220.2, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.0, туслах үйл ажиллагааны орлогоос 50.0, өмнөх оны үлдэгдлээс 32.5 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр батлагджээ.

*Хүснэгт 5. Нийт орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

Санхүүжилтийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1259</b>	<b>1166.7</b>
Орон нутгийн төсвөөс	1038.8	946.5
Орон нутгийн хөгжлийн сан	220.2	220.2
<b>Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас</b>	<b>84.5</b>	<b>40.8</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	2	1.7
Туслах үйл ажиллагааны орлогоос	50	39.1
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	32.5	
<b>ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>1343.5</b>	<b>1207.5</b>

*Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 946.5, ОНХС-ийн санхүүжилт 220.2, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, ОНХС-аас 40.8 сая төгрөг нийт 1,207.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,128.8 сая төгрөгийг зарцуулж 5.8 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогод төвлөрүүлэн 72.9 сая төгрөг нь орон нутгийн дансанд үлдэгдэлтэй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос оруулах 1.6, туслах үйл ажиллагааны орлого буюу сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 10.4, хүү, алданги 4.2, ОНХС-ийн малжуулахын авлага 19.6, өвс тэжээлийн орлого 3.3 сая төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлж, туслах үйл ажиллагааны орлогыг 10.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,128.8 сая төгрөг буюу 84.0 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 13.4, байр ашиглахтай холбоотой зардал 26.4, урсгал шилжүүлэг 26.7, хөрөнгийн зардалд 97.4, Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгө 48.9 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 6. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/*

Орлогын ангилал	2022 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	381.1	329.2	51.9
Нийт орлого ба тусламжийн дүн	377.1	308.7	68.4
Татварын орлого	377.1	308.7	68.4
Орлогын албан татвар	260.4	247.3	13.1
Хувь хүний орлогын албан татвар	260.4	247.3	13.10
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	213.9	220.1	(6.2)
Үйл ажиллагааны орлого	16.0	11.4	4.6
Шууд бус орлого	30.5	15.8	14.7
Хөрөнгийн албан татвар	105.1	47.3	57.8

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	30.0	14.1	15.9
Бууны албан татвар	1.1	1.2	(0.1)
Малын тоо толгойн албан татвар	50.0	14.0	36.0
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	24.0	18.0	6.0
Бусад татвар, төлбөр, хураамж	11.6	14.1	(2.5)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	5.9	6.5	(0.6)
Улсын тэмдэгтийн хураамж	1.5	1.3	0.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	3.4	4.0	(0.6)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.0	1.2	(0.2)
Газрын төлбөр	4.2	5.8	(1.6)
Газрын төлбөр	4.2	5.8	(1.6)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1.5	1.8	(0.3)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.1	1.5	(0.4)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.4	0.3	0.1
Татварын бус орлого	4.0	20.5	(16.5)
Торгуулийн орлого	2.0	16.8	(14.8)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2.0	-	2.0

*Эх сурвалж: Дөргөн сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Татварын орлогыг 329.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нийт орлогыг 51.9 сая төгрөгөөр буюу 13.6 хувиар тасарсан байна.

Орлого тасарсан гол шалтгаан нь цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 6.2 сая төгрөг, бусад татвар, төлбөр, хураамж 2.5, газрын төлбөр 1.6, байгалийн нөөц ашигласны төлбөр 0.3, татварын бус орлого 16.5 сая төгрөгөөр тус тус орлого давуулан биелүүлж, малын тоо толгойн албан татвар 36.0, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 15.9, иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого 6.0, шууд бус орлого 14.7, үйл ажиллагааны орлого 4.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн ЗДТГ-аас 15.2, аймгийн ИТХ-аас 1.4, Статистикийн хэлтсээс 0.8, БОАЖЯ-аас 0.9, ЗГ-ын ундны усны хөнгөлөлт 0.9, аймгийн Онцгой байдлын газраас 6.8, сумын ЗДТГ-ын үндсэн данснаас 11.9, газрын дуудлага худалдааны 1.5, хайгуулын эрх авах орлого 1.5 барьцаа 0.4 сая төгрөг нийт 41.3 сая төгрөгийн орлого бүрдүүлснээс, хөнгөлөлттэй үнээр хивэг худалдан авахад 10.0 сая, хагас жилийн мал тооллогын зардалд 0.8, хог хаягдлын зардалд 0.9, Дөрвөд угсаатны өв соёлын анхдугаар наадамд 5.0, Хар усан нуурын нуур хамгаалалтын зардал 1.5, бусад үйл ажиллагаанд 2.0 сая төгрөг зарцуулж орон нутгийн төсөвт 21.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дөргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүү нягтлан бодох бүртгэл, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 1/62 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,405.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 15.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдал тооцох хувийг 75 хувиар буюу 11.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗДТГ, ИТХ-ын төсвөөс тушаал шийдвэргүй, анхан шатны баримтгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй зардалд 7.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд сумын ЗДТГ-ын цалингийн зардлаас бусад зардлын таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын ажил гүйлгээг, төсөв санхүүтэй холбоотой бүрэн мэдээлээгүйг аудитын явцад залрууллаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 1.9 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулан, 149.1 сая төгрөгийн 1 албан шаардлага хэрэгжилтийн шатандаа, 4 зөвлөмжийг биелүүлэн ажиллаж хэрэгжилт 78.3 хувьтай байна.

Хүснэгт 7. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/сая. төгрөгөөр/						
	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1.9	2	1.9	-	-	100
Албан шаардлага	1	149.1		75.1	1	74.0	50.4
Зөвлөмж	5	168.2	4	141.3	1	26.9	84
Нийт дүн	8	319.2	6	218.3	2	100.9	78.3

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дөрвөд угсаатны өв соёлын анхдугаар наадмын үйл ажиллагааны зардал, сумын ЗДТГ болон малын шүлхий өвчний шатахууны зарцуулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын биелэлтүүдийг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 457.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залрууллаа. Үүнд:

- ОНХС-ийн өмнөх оны 20.7 сая төгрөгийн авлага, ИТХ-ын тайланд нэмэлтээр орсон орлогыг санхүүгийн үр дүнгийн тайланд зөрүүтэй бүртгэсэн,
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 119.9 сая төгрөгөөр,
- Өглөг 22.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасан,
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх сумын төвийн гэрэлтүүлгийн ажил гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөөтэй холбоотой 39.5 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилан олгосон авлагаар бүртгээгүй,
- Өмнөх үеийн үр дүн болон тайлант үеийн үр дүнг 255.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулсан.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 23.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 0.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 22.4 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

## **5.1 Төлбөрийн акт**

### **5.1.1 Сумын ЗДТГ-ын холбоотой төлбөрийн акт**

- ✓ Албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүй, авлагаар бүртгээгүй, тушаал шийдвэрт тусгаагүй ажилтанд үр дүнгийн урамшуулалд нийт 0.7 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **5.1.2 Сумын ИТХ-ын холбоотой төлбөрийн акт**

- ✓ ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн тушаалаар 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-д "энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;" заалтуудтай нийцээгүй байна.

## **5.2 Зөвлөмж**

### **5.2.1 Зардалтай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ОНХС-аас тэрбум мод хөтөлбөрөөр "заг модны үрсэлгээ хийх" ажлын гэрээнд заасан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй, санхүүжилтийг бүрэн олгосон, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй Дөрвөд угсаатны өв соёлын наадмын үйл ажиллагааг санхүүжүүлсэн зэрэг арга хэмжээнд нийт 15.0 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 60.3.3-д "үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;", 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлагдаагүй зардал, арга хэмжээ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "жинхэнэ хэрэгжилтийн", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Иргэдийн санал аваагүй арга хэмжээг баталж ОНХС-аас санхүүжүүлэхгүй байх

### **5.3.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ИТХ-ын төлөөлөгчид анхан шатны баримтгүй унааны зардал олгосон, тушаал шийдвэр гаргаагүйгээр хөрөнгө зарцуулсан, шинэ жилийн арга хэмжээ, сумын Тэшүүрийн аваргын тэмцээн зохион байгуулж төсвөөс санхүүжүүлсэн, хог хаягдлын цэгийн хаалга хийх

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

материал авах зэрэгт 7.4 сая төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" гэсэн заалтуудыг мөрдөөгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтаар бүрэн баталгаажуулахгүй ажил гүйлгээг санхүүжүүлэхгүй байх

### 5.3.3 Ажил хавсруулан гүйцэтгэсэн тэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ИТХ-ын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ТҮ-ийн ажилтанг томилон 21.0 сая төгрөгийн ажил гүйлгээг гаргасан нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-д "энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;"

Өгсөн зөвлөмж: Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
					Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл зөрүүтэй тусгасан	1	119.9	1	119.9	1	119.9
Өглөг зөрүүтэй илэрхийлсэн	1	22.2	1	22.2	1	22.2
Санхүүгийн үр дүнгийн тайланд өмнөх оны авлагыг орлогоор тусгасан	1	20.7	1	20.7	1	20.7
Авлага зөрүүтэй илэрхийлсэн	1	39.5	1	39.5	1	39.5
Тайлант үеийн болон өмнөх үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	1	255.6	1	255.6	1	255.6
Дүн	5	457.9	5	457.9	5	457.9

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс					
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүй, авлагаар бүртгээгүй, тушаал шийдвэрт тусгаагүй ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон	1	0.3	1	0.3		
нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн тушаалаар үр дүнгийн урамшуулал олгосон	1	0.4	1	0.4		
ОНХС-ийн хөрөнгөөр тэрбум мод хөтөлбөрөөр “заг модны үрсэлгээ хийх” ажлын гэрээнд заасан хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй, санхүүжилтийг бүрэн олгосон, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй Дөрвөд угсаатны өв соёлын наадмын үйл ажиллагааг санхүүжүүлсэн	1	15.0			1	15.0
ИТХ-ын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ТҮ-ийн ажилтанг томилон ажил хавсруулан гүйцэтгүүлсэн	1	-			1	
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>15.7</b>	<b>2</b>	<b>0.7</b>	<b>2</b>	<b>15</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил				
Анхан шатны баримтгүй унааны зардал олгосон, тушаал шийдвэргүй, шинэ жилийн арга хэмжээ, сумын Тэшүүрийн аваргын тэмцээн зохион байгуулж төсвөөс зардал гаргасан, ЗД-ын нөөц хөрөнгөөс бөхөд хүндэтгэл үзүүлсэн, урлагийн тоглолтод хандив олгосон	1	7.4	1	7.4
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>7.4</b>	<b>1</b>	<b>7.4</b>

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 60/A2160424

Ховд

ХОА-2022/06/НА/-СТА-ТТЗ  
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэчийн тушаалаар 370.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3.3-д "энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх," гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 370000 /гурван зуун далан мянган төгрөгийг/-ийг хавсралтад заасны дагуу төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дөргөн сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Түмэннасан, нягтлан бодогч Б.Бадамцэцэг нарт хариуцуулав.
- 3.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Х.Болдбаатар* Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР *Д.Нарантуул* Д.НАРАНТУУЛ

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 61/A2160424

Ховд

ХОА-2022/06/НА/-СТА-ТТЗ  
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар цалингийн урьдчилгаа суутгаагүй, тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулалд 302.6 мянган төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 302558 /гурван зуун хоёр мянга таван зуун тавин найман төгрөгийг/-ийг хавсралтад заасны дагуу төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дөргөн сумын ЗДТГ-ын дарга Б.Баттогтох, нягтлан бодогч Б.Бадамцэцэг нарт хариуцуулав.
- 3.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ж.БОЛДБААТАР  
АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ